

## **XVII—XVIII ЗУУНЫ ЗААГ ДАХЬ ТӨВД ОРОНД БОЛСОН ЗАРИМ НЭГ ХЭРЭГ ЯВДАЛ**

Ш. СОНИНБАЯР

Төвдийн түүх судлалын асуудлын дотроос дундат эртний төвдийн нийгэм улс төрийн түүхэнд болсон зарим ээдрээтэй хэрэг явдлын тухай энд өгүүлэх юм. XVII зууны сүүлчээр Төвдийг нэг талаас Манж нар түрэмгийлэн эзлэхийг эрмэлзэх болсон хийгээд нөгөөгөөс Ойрадын төрийн зүгээс их л санаархах болсон үе байлаа. Улс төрийн ийм хурцадмал үед Төвдийн төрийн эрхийг тэргүүн сайд (Дэсрид) Санжаажамц (1653—1705) барьж байв. Эрдэм ухаанд үлэмж мэргэжсэн, улс төрийн ухаалаг бодлоготой Санжаажамцыг V Далай лам Лувсанжамц төрийн тэргүүнээр томилсон нь санамсаргүй хэрэг биш юм. Буриадын эрдэмтэн Цыбиков<sup>1</sup> V Далай ламын үед сайд болсон Санжаажамцыг их эрдэмтэй, дипломат байсан гэж дүгнэсэн байдаг. Санжаажамцыг чухам хэдэн онд сайд болсон тухай төвдийн түүхч Лондол лам, Гүнчин Жамъяншадва нарын бичсэнтэй адил Монголын түүхч Сүмбэ хамбо Ишбалжир, Лхүндүв бандид, Нанзад аграмба нарын зохиосон он дарааллын бичгүүдэд шороо хонин (1679) жил гэж дурдсан байна.

Дээр дурдсан эрдэмтэдийн зохиолд Санжаажамцын төрийн тэргүүн байсан хугацааны талаар усан морин (1702) жил сайдын тушаалаас гарсан гэж бичсэний дээр түүхч Нанзад аграмба «он дарааллын бичиг нүдний баяр хурим»<sup>2</sup> гэдэг зохиолдоо зарим түүхчид Санжаажамцыг 24 жил, 31 жил төрийн эрх барьсан гэж үздэгийг сайтар шинжлэх хэрэгтэй гэж эргэлзсэн байдаг. Дээрх баримтаас үндэслэн 1679—1702 онуудад нийт 24 жил Төвдийн Төрийн хэргийг эрхэлж байсан гэж үзэж болно. 1682 онд V Далай лам таалал төгссөнийг нуун Далай ламын нэрийн өмнөөс Санжаажамц төрийн бодлогыг үргэлжлүүлэн явуулж байв.

V Далай ламыг таалал төгссөнийг нуух болсон шалтгааны тухай хэдэн баримт дурдая. XIV Далай лам өөрийнхөө намтарт<sup>3</sup> V Далай лам таалал төгсөхийнхөө өмнөхөн Санжаажамцад гэрээслэхдээ хэрэв намайг байхгүй болсныг бусад мэдвэл Будлан ордныг барьж дуусгах их ажил тасалдах шалтгаан болох тул нуух хэрэгтэй гэсний дагуу 15 жил нуусан юм гэж бичсэн байдаг. Мөн төвд хэлээр гардаг Лхасын 1982 оны сэтгүүлийн<sup>4</sup> доторхи «VI Далай лам Цаянжамцын домгийг тойм төдий шинжлэх нь» гэдэг өгүүлэлд тэр үед Дэсрид Будлан ордныг барих их ажилтай завгүй байсны гадна чухам нуух хэрэг нь улс төрийн үйл явдалтай холбоотой гэжээ. Бас Цыбиков тэмдэглэхдээ: гол учир нь төрөө алдахгүйн тулд нуусан юм гэв. Дээрх мэдээ сэлтээс үзэхэд Санжаажамц нь Төвдийн бүрэн эрхт байдлыг хамгаалж Манж, Зүүнгарын эрхшээлд орохгүйн тулд V Далай ламыг таалал болсныг нуусан бололтой байна. БНМАУ-ын түүхэнд<sup>5</sup> тэмдэглэхдээ Далай ламын тэргүүн сайд див хэмээх Санжаажамц далай ламыг нас барснаас хойш 16 жилийн турш түүний нэрийг зээлдэн ашиглаж Манжийн хааныг хууран мэхэлж Галдантай харилцаж байсан нь хожим илэрч билээ гэж бичсэн бий.

Санжаажамц нь 1683 онд төрсөн Цаянжамцыг 1697 онд VI Далай лам гэж нийтэд зарлах үедээ Манжийн Энх-Амгалан хааны сонорт тусгайлан мэдэгдээгүй явдалд Энх-Амгалан хаан их хилэгнэн занасан боловч Жанжаа хутагт Агваанчойндонг явуулж VI Далай ламыг залах ёслолд оролцуулж VI Далай ламыг хүлээн зөвшөөрсөн байна. Үүний дараа Гүүш хааны ахмад хүү Данзандалай ханы хүү Лхавзан гэгч Санжаажамцтай тэрсэлдэх болсон хүний нэг шалтгаан нь Лхавзан манжтай холбоо тогтоохыг оролдсоны гадна Төвдийн түүхч Дүнгар Лувсанпэрэнлэйн<sup>6</sup> үзсэнээр Санжаажамц нь нинмаавын (ловон Бадамжунайн ёс) ёсыг илүүд үзэх ба Лхавзан гэлүгваагийн (зонховын ёс) ёсыг баримталдаг учраас хоорондоо эвдэрсэн юм гэсэн байна.

Энэ үед Зүүнгарын хан Цэвээнравдан Манжийн хаанд өргөсөн бичигтээ «Дэв нь их башир аргатан бөгөөд түүний шинээр залсан далай лам нь хуурамч бас Лхавзан далай ламыг шинээр залах дээрээс болж Санжаажамцтай өстөн дайсан болсон» гэж бичиж байв. Иймэрхүү байдлын дунд Дэв Санжаажамц 1702 онд тушаалаас бууж хүү Агваанринчиндээ төрийн хэргийг шилжүүлжээ. Дараа нь Лхавзан Санжаажамц нарын тэмцэл улам хурцадсаар 1705 онд Лхавзан Санжаажамцыг хорсож төвдийн хаан болсон байна.

Лхавзаны Санжаажамцыг алсан явдалд Энх-Амгалан хаан өөрийн элчийг илгээж Лхавзанг өндөр цолоор шагнаж байв. Лхавзан нь Төвдийг захирсан Монголын сүүлчийн хаан бөгөөд Төвдөд 12 жил хаан суусан байна. Лхавзан нь Санжаажамцын холбоотон VI Далай ламыг V Далай ламын хувилгаан биш хуурамч дүр гэж гүтгэсэн бичиг Энх Амгалан хаанд явуулсан нь VI Далай лам Цаянжавыг үгүй хийх гэсэн бодлого байв.

1706 онд Манжийн хааны элч Бадам бичээч зэрэг хүмүүс ирж VI далай ламыг ширээнээс буулган барихаар явах үед Лхасын сүсэгтэн олон ихэд дургүйцэн босоцгоож далай ламыгаа хамгаалж хориглон тэмцэх гэхэд Лхавзан хаан цэрэг хөдөлгөн байлдах үед Цаянжамц далай лам аймшиггүйгээр Монгол цэргийн дунд очиж баривчлагдан явжээ. VI далай ламыг Бээжинд хүргэгдэх замдаа 1706 онд Хөх нуурт таалал төгссөн гэж Төвд, Монголын ихэнх түүхч нар үздэг байжээ. Гэвч үнэн хэрэгтээ Цаянжамц далай лам сэрүүн тунгалаг аж төрсөөр 1746 онд Алагшаад таалал төгссөн гэдэг намтрыг<sup>7</sup> монгол лам Даржаа номун хан зохиосон байдаг.

«Шинэ толь»<sup>8</sup> сэтгүүлд хэвлэгдсэн «Дөрвөн Ойрадын түүх» гэдэгт Дивын залсан Цаянжамц нэрээ нууж Монголд бадарчлан явсан гэж байгаагаас үзэхэд Төвдийн улс төрийн гадна дотнын хямралаас болж хэлмэгдсэн Цаянжамц далай лам аргагүйн эрхээр эгэл дорд дүрийг үзүүлж явжээ. Яруу найрагч V Далай лам Цаянжамцын гунигт амьдралыг Төвдийн ард түмэн өнөө болтол халаглан ярьсаар түүний яруу шүлгийг уншсаар ирсэн байна. Сүүлийн үед академич Ц. Дамдинсүрэн гуай Цаянжамцыг нарийвчлан судлан эрдэм шинжилгээний дорвитой өгүүлэл<sup>9</sup> бичсэн юм. Лхавзан хаан 1707 онд Ишжамц гэдэг Төвдийг V Далай ламын хойд дүр Далай лам гэж өргөмжилсөн явдалд Төвдийн ард түмэн болон Монголын сүсэгтэн нар итгэхгүй байв. Энэ үед Ойрадын Цэвээнравдан нэлээд хүчирхэг болж Төвдийг эзлэхийг зорьж байв.

Лхавзангийн их хүү Галданданзан нь Зүүнгарын хан Цэвээнрав дангийн охинтой гэрлэхийг хүсэвч Лхавзан хориглосон боловч үгэнд оролгүй Зүүнгарын ханы охинтой ханилсан нь Цэвээнравданд аятайхан

шалтаг болж охиныг төвдөд хамгаалах нэрийн дор цэрэг оруулсан байна. 1716 онд Цэвээнравдан тайж их Цэрэндондовт 6000 цэрэг өгч Төвдийг эзлүүлэхээр явуулав. Зүүнгарын их цэрэг Төвдийг эзлэх аюул тулгарсанд Лхавзан хаан Манжаас тусламж гуйсан боловч манжийн цэрэг ирэхээс өмнө 1717 онд Зүүнгарын Цэрэндондовын цэрэг Лхавзангийн цэрэгтэй байлдсаар Лхасыг бүслэн эзлээд Лхавзанг алсан болно. Лхавзангийн залсан Далай лам Ишжамцыг шоронд хорьжээ. Зүүн гарын эрхшээлээс Төвдийг чөлөөлөхөөр Манжийн цэрэг ирж байлдан 1719 онд Төвдийн гүнд нэвтрэн байлдсаар 1720 онд Лхасыг чөлөөлсөн байна. Шоронд байсан Ишжамцыг суллан Бээжид хүргүүлсэн. Энэ үед Хөх нуурын ноёд Литанд мэндэлсэн Галсанжамцыг 1721 онд VI Далай лам Цаянжамцын хувилгаан VII Далай лам гэж өргөмжлөв.

Төвд нь 1720 оноос хойш Манжийн хараат байдалд орсон гэж Зөвлөлтийн түүхч И. Я. Златкин<sup>10</sup> тэмдэглэсэн байна. XVII—XVIII зууны заагт болсон Төвдийн дотоод гадаад байдлыг товчлон үзэхэд ийм байна.

### НОМ ЗҮЙ

<sup>1</sup> **Цыбиков, Г. Ц.** Буддист паломник у святынь Тибета. Новосибирск 1981, т. 1. 144—145 стр.

<sup>2</sup> Нанзад аграмба **bstan risis mig gi dqa' ston** Их хүрээ бар 33-р тал.

<sup>3</sup> **Данзанжамц** XIV Далай лам **nges kyi yul dang mi dmangs** Дармасала 1963.

43-р тал

<sup>4</sup> **bod ljongs zhib' jug** Лхас 1982. 97-р тал

<sup>5</sup> БНМАУ-ын түүх, дэд боть УБ. 1968. 99-р тал

<sup>6</sup> **Дүнгар Лувсанпэрэнлэй bod kyi chos srid zung brel skor bshad pa** Бээжин 1983. 114-р тал.

<sup>7</sup> **Агваанлхүндүвдаржаа tshangs dbyang rgya mtso i gsang bai rnam thar** Бээжин 1981. 226 х.

<sup>8</sup> Шинэ толь, УБ. 1938 он 46-р тал

<sup>9</sup> **Ц. Дамдинсүрэн**, Монголын у/з-ын харилцаа холбооны асуудалд УБ 1987 191-р тал

<sup>10</sup> **И. Я. Златкин**, История джунгарского ханства. Москва 1983, 225 стр.